

# БОЛОВСРОЛЫН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ САЛБАРЫН НӨЛӨӨГӨӨР ХҮН АМЫН НУТАГШИЛТАНД ГАРЧ БҮЙ ӨӨРЧЛӨЛТҮҮД

Ц.Отгонхүү

ШУА-ийн Газарзүй-Геоэкологийн хүрээлэн, Нийгэм эдийн засгийн газарзүйн салбар,  
Э-шуудан: Ts.otgonkhuu@gmail.com

## Abstract

This paper included some results of educational service influence and its change detection study for distribution and spatial principle of population (2014-2016 topical study). We made following conclusions:

- In soum centers nearby aimag centers (up to 40 km), their educational service receivers moved to aimag center. In other words, these soums close to the aimag centers (up to 40 km) have a new approach that children usually study in the secondary schools at aimag center thus caused redundancy of educational service in soum centers.
- Population of soums with upper secondary school is growing. In other words, population of these soums is concentrated in sum center and covered by educational service more than other soums with basic secondary school.

Therefore, we need to conduct more detailed study and define changes of population distribution and settlements influenced by educational service. Also, we need to investigate influences of major habitation patterns, roads and other geographical factors.

**Түлхүүр үг:** Боловсролын үйлчилгээ, хүн амын нутагшилт, бүрэн дунд сургууль

## Оршил

Хүн амын шилжилт хөдөлгөөний нөлөөгөөр хотжилтын түвшин 67 хувьд хүрч, нийслэл, бүсийн тулгуур төв, аймгийн төв, сумын төв зэрэг хот суурин газруудад манай улсын нийт хүн амын 76 хувь нь амьдарч байна [1]. Улаанбаатарт шилжин ирэгч эрэгтэйчүүдийн шилжилтийн гол шалтгаан нь ажил эрхлэх (26.9%), суралцах (21.4%), үр хүүхдийнхээ ирээдүйг бодох (14.6%), эмэгтэйчүүдийн хувьд суралцах (34.3%), ажил эрхлэх (15.7%), төрөл садангаа бараадах (14.1%) зэрэг байна [2].

Мөн манай орны хувьд боловсролын үйлчилгээний хөгжлийн түвшин нутаг дэвсгэрийн хувьд ялгаатай байна. Тухайлбал: 2012-2013 оны хичээлийн жилийн байдлаар Улаанбаатар хотын Чингэлтэй дүүргийн 5-р сургуульд 56 бүлгийн 2160 хүүхэд суралцаж, бүлэг дүүргэлт 38,5 байхад Төв аймгийн Сэргэлэн сумын сургуульд 8 бүлгийн 43 хүүхэд суралцаж, бүлэг дүүргэлт 5,3 байгаагаас харагдаж байна [3]. Эдгээрээс улбаалан малчид суурьшилд тэмүүлэх, зах хязгаар нутгаас хот суурин бараадах, Улаанбаатарт хэт төвлөрлийг бий болгох зэрэг олон үр дагаврыг бий болгож байна. Тийм учраас боловсролын үйлчилгээний салбарын хүн амын нутагшилт, суурьшилтанд үзүүлж буй нөлөөллийг шинжлэх ухааны үндэслэлтэйгээр нарийвчлан судлах судалгааны ажил шаардлагатай байна.

### Судлагдсан байдал

Монгол орны боловсролын үйлчилгээний газарзүйн судалгааны талаар дорвитой томоохон судалгаа хийгдэж байгаагүй боловч ШУА-н Газарзүйн хүрээлэнгийн Нийгэм эдийн засгийн газарзүйн секторт С.Гэрэлээ анхлан судалгаа явуулж эхэлжээ. Тэрээр боловсролын үйлчилгээний газарзүйн тойргийг Монгол орны нөхцөлд тохируулан гаргаж ирсэн бөгөөд сургуулийн үйлчилгээний тойргийг тогтоохдоо хот суурин, сумдын хүн амын тоо, шилжих хөдөлгөөний хэтийн төлөв, сум аж ахуйн төв хот суурины эдийн засгийн болон үйлчилгээний харилцаа холбооны уламжлал, хэтийн төлөв, зам тээврийн бололцоо, аж ахуй-үйлдвэрлэлийн нийтлэг шинж зэргийг харгалzan үзэх нь зүйтэй гэсэн байна [4].

Энэхүү судалгааны ач холбогдол нь өнөө үед материаллаг үйлдвэрлэлээсээ илүү хурдацтай хөгжиж байгаа үйлчилгээний салбарын [5] нэлээд хүчтэй хөгжсөн салбарын нэг болох боловсролын үйлчилгээний салбарыг [6] хүн амын нутагшилттай холбогдуулан судалсанд оршино.

### Судалгааны аргазүй

Бидний судалгааны ажлын зорилго нь хүн амын нутагшилт, суурьшилд боловсролын үйлчилгээний нөлөөгөөр гарч буй өөрчлөлтүүдийг тодорхойлох бөгөөд дараах таамаглалуудыг дэвшүүлсэн. Үүнд:

1. Аймгийн төвтэй ойр сумын хүн ам нь аймгийн төвдөө татагдаж байна.
2. Бүрэн дунд сургуультай сумдын хүн ам нь тогтвортой, өсөлттэй байна.

Эдгээр таамаглалуудаа баталгаажуулахын тулд Монгол орны төв хэсгийн 13-н аймгийн 194 сумдын боловсролын үйлчилгээний үзүүлэлтүүдийг цуглуулж, төлөөлөл болгон сонгогдсон 6 аймгийн 12 сум тус бүрийн 20 малчин өрхөөс асуулга авч дүн шинжилгээ хийлээ.

Бид хээрийн судалгааг аймгийн төвөөс алслагдсан байдал, автозамаар холбогдсон байдал, тэнхлэгээс алслагдсан байдал зэрэг үзүүлэлтүүдийг харгалzan сонгосон Архангай аймгийн Тариат, Булган аймгийн Орхон, Хангал, Баяннуур, Рашиант, Дундговь аймгийн Өндөршил, Цагаандэлгэр, Өмнөговь аймгийн Ханхонгор, Цогццэций, Өвөрхангай аймгийн Хархорин, Төв аймгийн Баянхангай, Эрдэнэсант сумдад явуулсан.


Цуглуулсан анхдагч тоон мэдээ, материал, батлагдсан аргазүйн дагуу малчдаас авсан асуулгынхаа мэдээг судалгааны суурь онуудын давтамжаар харьцуулалт хийх, өсөлт, бууралтын зүй тогтлыг тооцох, үнэлгээ өгөх, эрэмбэлэх зэрэг статистикийн болон газарзүйн судалгааны нийтлэг аргуудыг хэрэглэн анхан шатны боловсруулалт хийж, дүгнэлт гаргасан.



1 дүгээр зураг.

### Судалгаанд хамрагдсан нутгийн тойм

Бидний судалгаа Монгол орны 13 аймгийн 194 сумдыг хамарч байгаа бөгөөд энэ нь нийт сумдын 58,6 хувь болж байна. Эдгээр 194 сумдын 62,3 хувь нь буюу 121 сум нь бүрэн дунд боловсролын сургуультай, 37,6 хувь нь буюу 73 сум нь суурь боловсролын сургуультай байна.



2 дугаар зураг.

Судалгаанд хамрагдсан сумдын дунджаар, 2012-2013 оны хичээлийн жилийн дүнгээр авч үзвэл ерөнхий боловсролын сургуулийн хамран сургалтын бохир жин 79,01 хувьтай, 1-р ангид элсэгчдийн бохир жин 78,82 хувьтай, нэг багшид ногдох сургчийн тоо 22,5 байна.

### Судалгааны үр дүн

**1. Аймгийн төвтэй ойролцоо сумдын (40 хүртэлх км) сумын төвүүдийн боловсролын үйлчилгээний үүрэг нь аймгийн төвдөө шилжиж байна.**

2012-2013 оны хичээлийн жилийн байдлаар судалгаанд хамрагдсан сумдын дунджаар ерөнхий боловсролын хамран сургалтын бохир жин 78,54 хувьтай, 1-р ангид элсэгчдийн хамран сургалтын бохир жин 77,08 хувьтай байна.


1 дүгээр хүснэгт. Боловсролын үйлчилгээний зарим үзүүлэлтүүд,  
сумдаар 2013 он

№	Сумын нэр	Aймгийн төвөөс	Ерөнхий боловсролын	1-р ангид
		алслагдсан зайд км-ээр	хамран сургалтын бохир жин	элсэгчдийн бохир жин
1	Өндөршил	182	84,56	83,33
2	Ханхонгор	25	40,82	20,45
3	Цагаандэлгэр	148	67,94	92,86
4	Цогтцэций	98	103,75	103,85
5	Хангал	113	81,33	48,48
6	Орхон	22	29,18	25,00
7	Баяннуур	176	79,28	56,10
8	Баянхангай	131	67,36	88,89
9	Рашаант	250	108,68	89,04
10	Тариат	166	86,46	105,06
11	Хархорин	138	98,48	100,47
12	Эрдэнэсант	247	94,60	111,43
13	Дундаж	141	78,54	77,08

Эх сурвалж: Аймгуудын статистикийн товчоон, 2013

Харин 2012-2013 оны хичээлийн жилийн байдлаар аймгийн төвөөсөө 22 км зйтай Булган аймгийн Орхон сумын ерөнхий боловсролын хамран сургалтын бохир жин 29,18 хувь, 1-р ангид элсэгчдийн хамран сургалтын бохир жин 25,00 хувьтай, аймгийн төвөөсөө 25 км зйтай Өмнөговь аймгийн Ханхонгор сумын ерөнхий боловсролын хамран сургалтын бохир жин 40,82 хувь, 1-р ангид элсэгчдийн хамран сургалтын бохир жин 20,45 хувьтай байна.


Аймгийн төвтэй ойр (40 хүртэл км) сумдын сумын төвийн боловсролын үйлчилгээний хөгжлийн түвшин доогуур байгаагаас шалтгаалан тухайн сумын хүүхдүүд ихэвчлэн аймгийн төвийн сургуулиудад суралцах хандлагатай байгаа бөгөөд энэ бүхнээс харахад аймгийн төвтэй ойр сумдын сумын төвүүдийн боловсролын үйлчилгээний үүрэг нь аймгийн төвдөө шилжиж байна гэсэн дүгнэлтийг хийж болохоор байна.



1 дүгээр график. Аймгийн төвтэй ойролцоо сумдын боловсролын үйлчилгээний зарим үзүүлэлт 2006 он, 2010 он, 2013 он,  
Эх сурвалж: Аймгуудын статистикийн товчоон, 2013

## 2. Бүрэн дунд сургуультай сумдын хүн ам өсөлттэй, тогтвортой суурьшилтай байна.

Сумын сургуульд хүүхэд нь сурч байгаа эцэг эхчүүд 9-р анги дэвшүүлэн суралцуулахад сумын сургууль цөөн хүүхэд авдаг гэсэн ойлголттой байдаг бөгөөд үр хүүхдээ аль болох эртхэн 12 жилийн сургуульд элсүүлэхийг эрмэлздэг байна [7]. Энэ нь тухайн сум, суурингийн сургуулийн төрөл (бүрэн дунд, суурь боловсролын сургуультай эсэх) хамран сургалтын бохир жин, цаашлаад хүн амын нутагшилт, суурьшилд нөлөөлдөг болохыг илтгэж байна.



2 дугаар график. Сумын хүн амын тоо, тооны өөрчлөлт,  
Эх сурвалж: Аймгуудын статистикийн эмхэтгэл, 2014

Судалгаанд хамрагдсан сумдыг бүрэн дунд сургуультай болон суурь боловсролын сургуультай гэсэн бүлэгт хувааж суурин хүн амын тоог харьцуулж үзэхэд бүрэн дунд сургуультай сумын хүн амын жилийн өсөлтийн хувь тогтвортой өсөлттэй байна. Өөрөөр хэлбэл хүн амын өсөлт бүрэн дунд сургуультай сумдад тогтвортой байгааг хүн амын жилийн өсөлтийн хувь нь суурь боловсролын сургуультай сумдын дунджаар 2011/2010, 2012/2011, 2013/2012 онуудаар авч үзэхэд харгалзан -0.75, -0.51, 1.35 хувьтай байгаа бол бүрэн дунд сургуультай сумын дунджаар авч үзэхэд 3.27, 3.36, 2.72 хувьтай байгаагаас харж болно.

Судалгаанд хамрагдсан сумдын 2012-2013 оны хичээлийн жилийн дүнгээр ерөнхий боловсролын сургуулийн хамран сургалтын бохир жинг авч үзэхэд суурь боловсролын сургуультай сумдад дунджаар 63,85 хувьтай байхад бүрэн дунд сургуультай сумдын дундаж нь 93,22 хувьтай байна. Өөрөөр хэлбэл суурь боловсролын сургуультай сумдын сургуулийн насны 10 хүүхэд тутмын 6 нь, бүрэн дунд сургуультай сумдын сургуулийн насны 10 хүүхэд тутмын 9 нь сумынхаа сургуульд суралцаж байна.

2 дугаар хүснэгт. Сумын ерөнхий боловсролын сургуулийн хамран сургалтын бохир жин, сургуулийн хэв шинжээр, 2006 он, 2013 он

Сургуулийн төрөл	Сумын нэр	Ерөнхий боловсролын сургуулийн хамран сургалтын бохир жин		Өөрчлөлтийн хувь 2013/2006
		2006 он	2013 он	
Суурь боловсролын сургуультай сумд	Өндөршил	65,75	84,56	18,81
	Цагаандэлгэр	49,23	67,94	18,71
	Орхон	31,89	29,18	-2,71
	Баяннуур	70,45	79,28	8,83
	Ханхонгор	55,63	40,82	-14,81
	Хангал	86,77	81,33	-5,44
	Дундаж	59,95	63,85	3,90
Бүрэн дунд боловсролын сургуультай сумд	Цогтцэций	75,18	103,75	28,56
	Баянхангай	66,86	67,36	0,50
	Рашаант	94,13	108,68	14,55
	Тариат	77,69	86,46	8,76
	Хархорин	99,13	98,48	-0,65
	Эрдэнэсант	81,10	94,60	13,50
	Дундаж	82,35	93,22	10,87

Эх сурвалж: Аймгуудын статистикийн эмхэтгэл, 2014

Суурь боловсролын сургуультай сумдын нийт дүнгээр судалгаанд хамрагдсан нийт малчин өрхийн 39.13 хувь нь өөр суурин газарт хүүхдээ сургуульд явуулж, 27.78 хувь нь өөр сууринд газар өмчлөн авч, 22.22 хувь нь өөр суурин газарт хашаа, гэр, байшинтай байна. Өөрөөр хэлбэл боловсролын үйлчилгээний хувьд суурь боловсролын сургуультай сумдын сумын төвдөө татагдах байдал нь харьцангуй сүл байна.

3 дугаар хүснэгт. Суурь боловсролын сургуультай сумдын  
зарим үзүүлэлтүүд, 2013 он

Сумын нэр	Судалгаа авсан нийт өрхийн тоо	Сургуулийн насны хүүхэдтэй өрхийн тоо	Үүнээс		
			Хүүхдээ өөр сууринд сургуульд явуулдаг өрхийн эзлэх хувь	Өөр сууринд газраа өмчилж авсан өрхийн эзлэх хувь	Өөр суманд хашаа, гэр, байшинтай өрхийн эзлэх хувь
Өндөршил	21	13	38.46	0.00	0.00
Цагаандэлгэр	19	11	27.27	66.67	60.00
Орхон	20	11	81.82	50.00	0.00
Баяннуур	20	11	9.09	20.00	16.67
Нийт	80	46	39.13	27.78	22.22

Эх сурвалж: Хээрийн судалгаа 2013, 2014 он

Эдгээрээс дүгнэж үзэхэд сумын хүн ам нь сумынхаа төвд татагдаж боловсролын үйлчилгээнд хамрагдах байдал нь бүрэн дунд боловсролын сургуультай сумдад суурь боловсролын сургуультай сумдаасаа илүү байгаа бөгөөд үүнээс шалтгаалан бүрэн дунд боловсролын сургуультай сумдад хүн ам өсөлттэй, тогтвортой суурьшилтай байх хандлагатай байна.

### Дүгнэлт

Энэхүү судалгааны ажлыг гүйцэтгэсний үр дүнд өмнө дэвшүүлсэн таамаглалууд батлагдсан бөгөөд дараах дүгнэлтэнд хүрч байна.

- Аймгийн төвтэй ойролцоо сумдын (40 хүртэлх км) сумын төвүүдийн боловсролын үйлчилгээний үүрэг нь аймгийн төвдөө шилжиж байна. Өөрөөр хэлбэл аймгийн төвтэй ойр (40 хүртэл км) сумдын сумын төвийн боловсролын үйлчилгээний хөгжлийн түвшин доогуур байгаагаас шалтгаалан тухайн сумын хүүхдүүд ихэвчлэн аймгийн төвийн сургуулиудад суралцах хандлагатай байна.
- Бүрэн дунд боловсролын сургуультай сумдын хүн ам өсөлттэй, тогтвортой суурьшилтай байна. Өөрөөр хэлбэл сумын хүн ам нь сумынхаа төвд татагдаж боловсролын үйлчилгээнд хамрагдах байдал нь бүрэн дунд боловсролын сургуультай сумдад суурь боловсролын сургуультай сумдаасаа илүү байна.

Цаашид энэхүү судалгааг улам гүнзгийрүүлж боловсролын үйлчилгээний нөлөөгөөр хүн амын нутагшилт, суурьшилд гарч байгаа өөрчлөлтийг тодорхойлсны үндсэн дээр түүнд нөлөөлж буй тэнхлэг, томоохон суурингууд, автозам зэрэг газарзүйн хүчин зүйлсийн нөлөөллийг илрүүлж зүй тогтлыг тайлбарлах шаардлагатай байна.

### Талархал

Судалгааны ажил бичихэд үнэтэй зөвлөгөөгөө харамгүй хайлласан сэдвийн удирдагч Б.Батбуян (Ph.D) болон салбарын судлаачдад талархсанаа илэрхийлье.

### Ашигласан материалын жагсаалт

1. YCX, “Монгол улсын статистикийн эмхтгэл-2013” 2014 он, Улаанбаатар
2. ХАССТ, “Монгол улсын хүн амын дотоод шилжих хөдөлгөөний микро түвшний судалгаа” 2001 он
3. БШУЯ, “Боловсролын салбарын статистик мэдээллийн эмхтгэл”, 2013 он, Улаанбаатар
4. С.Гэрэлээ “Ерөнхий боловсролын сургуулийн зохистой байршилтын зарим асуудал”, МОГЗА №20, 1982 он
5. М.Баянтар ба бусад, “Газарзүй III” сурх бичиг, 2011 он, Улаанбаатар
6. С.Гэрэлээ “Ерөнхий боловсролын сургуулийн зохистой байршилтын зарим асуудал”, МОГЗА №20, 1982 он
7. Гита Штейнер Хамси, “Боловсролын төлөөх нүүдэл” Улаанбаатар, 2001 он